Нийслэлийн Орон сууцны бодлогын газар
2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн Аудитын зөвлөмжийн биелэлт

2025.09.10

| № | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | АГАДҮТ-ийн дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн (мян. төгрөгөөр) | Шалгуур үзүүлэлт<br>Стандартын заалт | Байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| A | САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ | | | | | | |
| 1 | Зөвлөмж өгөх | Бараа материал | Санхүүгийн тайлангийн нөөцийн бараа дансанд бүртгэлтэй байгаа 56747.8 м.кв 7,882,044.1 мянган төгрөгийн газрын эзэмших эрхийн гэрчилгээ, холбогдох анхан шатны баримтууд байхгүй байна. | - | УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх | Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын санхүүгийн тайлангийн нөөцийн бараа дансанд бүртгэлтэй байгаа 56747.8 м.кв буюу7,882,044.1 мянган төгрөгийн газрын эзэмших эрхийн гэрчилгээ, холбогдох анхан шатны баримтуудыг холбогдох газар луу шилжүүлэхээр НЗДТГ-ын Зөвлөлийн хурлаар оруулахаар саналын хуудсыг холбогдох албан тушаалтангуудад танилцуулах. | Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа 56747.8 м.кв 7,882,044.1 мянган төгрөгийн газрын эзэмших эрхийг НЗДТГазарт шилжүүлэхээр 2025 оы 03 дугаар сарын 11-нд Зөвлөлийн хуралд танилцуулахаар саналаа илгээсэн. Холбогдох байгууллагуудаар хэлэлцэгдэж байна. |
| | | | дүн | 0.00 | | | |
| B | САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ | | | | | | |
| 1 | Зөвлөмж өгөх | Урсгал зардал | Тайлант онд 26 албан хаагчид 1556 цагийн 33,305.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл, 10 албан хаагчид 47,718.5 мянган төгрөгийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин олгосон байна. Төсвийн шууд захирагч нь батлагдсан орон тоог бүрэн ажиллуулж хүний нөөцийг хангах, ажил хавсран гүйцэтгэж байгаа хүний ажлын ачаалал, амралтыг зохицуулж, зохион байгуулалт хийгээгүй байна. | 81,024.10 | УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4 Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх. | Төсвийн шууд захирагчийн батлагдсан орон тоог бүрэн ажиллуулж хүний нөөцийг хангах, ажил хавсран гүйцэтгүүлсэн албан хаагчийн тоог бууруулах, нэмж ирсэн Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр батлуулах ажлыг эрчимжүүлэх. | • НЗД-ын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/443 дугаар захирамжаар 43 орон тоо батлагдсанаас шинээр байгуулагдсан Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн 10 албан тушаалын тодорхойлолт батлагдаагүй байна. Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор 4 албан хаагчаар албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэн ажиллаж байна. • 2025 оны эхний хагас жилийн байдлаар НЗД-ын 2025 оны 1 дүгээр сарын 13-ны А/33 албан захирамжийн шийдвэрээр 11 албан хаагчдад төгрөгний илүү цагийн хөлс 3706158 төгрөг олгосон.<br>• Ажил ачаалал, амралтыг зохицуулах зорилгоор газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг арилган, 2025 оны 03 дугаар сарын 01-ни өдрөөс эхлэн 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл ажлын цагийн уян хатан зохицуулалтаар ажилласан. |
| 2 | Зөвлөмж өгөх | Хөрөнгийн зардал | Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 21,447.6 мянган төгрөгийн бараа материалыг цахим дэлгүүрээс аваагүй байна. | 21,055.30 | УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, 5.2.1.7.4 голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх. | Цахим дэлгүүрт худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган баталгаажуулан худалдан авалт хийх | 2025 оны шууд худалдан авалтын төлөвлөгөө гарган Газрын даргаар баталгаажуулсан. |
| 3 | Зөвлөмж өгөх | Хөрөнгийн зардал | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлээгүй байна. | - | УСНББОУС-24 Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн тодруулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4 Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх. | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган tender.gov.mn цахим системд мэдээлэх | Шууд худалдан авалтын төлөвлөгөөг tender.gov.mn цахим системд мэдээлсэн. |
| | | | Дүн | 102,079.40 | | | |

Хянасан:
Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж. Болортуяа

Бэлтгэсэн:
Ахлах нягтлан бодогч: Ю.Нанжид